

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2025 оны 11 дүгээр сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСАГ 2024 ОНД

ДНБ-ий өсөлт

(2024 он)

5.1 хувь

Гадаад валютын нөөц

(2024 оны эцэс)

5.5 тэрбум \$

Инфляц

(2024 оны 12 дугаар сар)

9.0 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2024 оны эцэс)

-776 тэрбум ₮

Экспорт

(2024 оны эцэс)

15.8 тэрбум \$

Импорт

(2024 оны эцэс)

11.6 тэрбум \$

ГШХО

(2024 он)

4.2 тэрбум \$

Зээлийн хүү

(2024 оны 12 дугаар сар)

16.9 хувь

Ажилчдын тоо

(2024 он)

1.36 сая

*2024 оны байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 61.3 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 он)

2.9 хувь

*ХҮИ 2020=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны эцэс)

108.4 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 он)

9.0 хувь

ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2025.11

ДНБ-ий өсөлт

(2025 оны 3 дугаар улирал)

5.9 хувь

Гадаад валютын нөөц

(2025 оны 11 дүгээр сар)

5,886 сая \$

Инфляц

(2025 оны 11 дүгээр сар)

8.2 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 11 дүгээр сар)

-1,774 тэрбум ₮

Экспорт

(2025 оны 11 дүгээр сар)

13.7 тэрбум \$

Импорт

(2025 оны 11 дүгээр сар)

10.2 тэрбум \$

ГШХО

(2025 оны 2 дугаар улирал)

1.4 тэрбум \$

Зээлийн хүү

(2025 оны 11 дүгээр сар)

17.4 хувь

Ажилчдын тоо

(2025 оны 3 дугаар улирал)

1.39 сая

*111 улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.7 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2025 оны 3 дугаар улирал)

1 хувь

*ХҮИ 2020=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 3 дугаар улирал)

115.0 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.


Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 3 дугаар улирал)

4.0 хувь



Эдийн засгийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 5.9 хувь хүрч, сэргэлээ. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрчимжиж нийт өсөлтийг дэмжиж эхэлсэн бол цэвэр татвар буурч, өсөлтийг хязгаарлав. Хөдөө аж ахуй, боловсруулах, эрчим хүч, барилгын салбар өсөлтийг дэмжсэн бол худалдаа, тээврийн салбар агшиж өсөлтийг сааруулсан хэвээр байна.




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
(салбараар)

ДНБ	2024.III	2025.III
Хөдөө аж ахуй	-25.0	33.8
Уул уурхай	11.3	8.2
Боловсруулах	-2.4	7.7
Цахилгаан, ус	5.2	8.4
Барилга	10.6	22.2
Худалдаа	12.7	-5.1
Тээвэр	10.2	-6.1
Мэдээлэл, холбоо	16.1	10.0
Үйлчилгээний бусад	9.7	4.2
Цэвэр татвар	13.3	-1.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2025 оны 3 дугаар улиралд **5.9 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Хөдөө аж ахуй 33.8 хувиар тэлж, өсөлтийн 3.4 нэгж хувийг, уул уурхай 8.2 хувиар тэлж, өсөлтийн 1.1 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 10.6 хувиар өсөж өсөлтийн 1.1 нэгж хувийг бүрдүүлэв.
- Үйлчилгээний салбар /үйлчилгээний бусад салбар өссөн, тээвэр, худалдаа агшсан/ 1.3 хувиар өсөж, өсөлтийн 0.6 хувийг бүрдүүллээ.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 1.8 хувиар агшиж, өсөлтийг 0.3 нэгж хувиар хязгаарлав.
- Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбар болон уул уурхайн салбарын өсөлт голлон нөлөөлөв.
- Боловсруулах, барилга цахилгаан, усан хангамж, тээвэр худалдаанаас бусад үйлчилгээний салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, өсөлтөд эергээр нөлөөллөө.
- Харин нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого буурснаар тээврийн салбар агшив.
- Мөн хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа буурч, худалдааны борлуулалт агшсан байна.
- Уул уурхайн салбар 2025 оны 3 дугаар улиралд 8.2 хувиар өслөө.
- Үүнд зэсийн баяжмал үйлдвэрлэл 1.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
- Харин нүүрс, алт, газрын тос зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөлтийг хязгаарлалаа.
- Тухайлбал, нүүрс олборлолт 68.9 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар, газрын тос олборлолт 10.6 хувиар, алт олборлолт 8.4 хувиар тус тус буурав.
- ХАА-н салбар 2025 оны 3 дугаар улиралд жилд 33.8 хувиар өслөө.
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн байж, бойжсон төлийн тоо толгой 21.1 саяд хүрч (төл бойжилт 98.4 хувь) өмнөх оны мөн үеэс 5.6 сая толгой малаар нэмэгдэн, том малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 7.9 сая толгой малаар буурсны голлох нөлөөгөөр сүүлийн хоёр жил дараалан буурсан хөдөө аж ахуйн салбар сэргэв.



Эрэлт талаас өсөлтийг өрхийн хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал болон үйлчилгээний экспорт дэмжлээ.

ДНБ-ИЙ ӨСӨЛТ



- Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 7.4 нэгж хувийг өрхийн хэрэглээ, 6.5 нэгж хувийг үндсэн хөрөнгийн хуримтлал, 1.3 нэгж хувийг цэвэр экспорт бүрдүүлсэн байна.
- Харин эргэлтийн хөрөнгийн бууралт өсөлтийг 9.1 нэгж хувиар, төрийн хэрэглээ 0.2 нэгж хувиар бууруулсан байна.

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ




- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар буурсан бол өрхийн хэрэглээний өмнөх улирлын өсөлт хадгалагдаж, 9.7 хувиар нэмэгдлээ.

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН ӨСӨЛТ (жилийн өсөлтийн хувь)



- Үндсэн хөрөнгийн хуримтлал 18,8 хувиар өсөхөд орон сууцны бус барилга байгууламжийн нөөц бодитоор 30,1 хувиар, орон сууцны барилга 22,8 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөллөө. Мөн өмнөх онд бууралттай байсан биологийн өсөж үрждэг хөрөнгө өсөлтэй гэрч хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүллээ.


ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ




- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 2.4 хувиар өссөн бол бараа, үйлчилгээний импортын өсөлт үргэлжлэн саарч 0.3 хувь болсон нь цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж байна.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 11 сард 1.6 хувиар өслөө. Уул уурхайн салбарт зэс, төмрийн хүдрийн олборлолтын биет хэмжээ болон үнэ өссөн нь голлон нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний 11 сард 47.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар өслөө.
- Зэсийн баяжмалын үйлдвэрлэл өссөн ч газрын тос болон уул уурхайн туслах үйл ажиллагааны үйлдвэрлэл буурснаар уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 1.3 хувиар буурлаа.
- Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл (нэрлэсэн дүнгээр) 2025 оны эхний 11 сард 9 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон төмөрлөг бус эрдэс бодисын үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг* уул уурхайн салбар, түүний дотор 43 хувийг нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2025 оны эхний 11 сард 85.3 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар буурлаа. Харин тухайн сараар буюу 2025 оны 11 дүгээр сарын байдлаар нүүрс олборлолт өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар өссөн байна.

*2024 оны байдлаар

УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

(голлох бүтээгдэхүүнээр)

	өмнөх оноос өөрчлөлт:
Зэсийн баяжмал	1,913 мян.тонн 37.1%
Газрын тос	3.5 сая баррель -10.1%
Алт	11.6 тонн -0.7%
Төмрийн хүдэр	12.2 сая.тонн 29.8%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2025 оны эхний 11 сард нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 37.1 хувиар өсөж 1,913 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 12.2 сая тоннд хүрч, 29.8 хувиар өссөн байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс доогуур хэвээр байна.




- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2025 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар өссөн байна.
- Үнэ өссөн:
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 13.4 хувиар;
 - Ундаа үйлдвэрлэл 19.9 хувиар;
 - Металлын хүдэр олборлолт 39.9 хувиар;
- Үнэ буурсан:
- Нүүрс олборлолт 33.3 хувиар;
 - Газрын тос олборлолт 5 хувиар.




Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 11 сард бодит дүнгээр 1.7 хувиар өсөв. Үүнд төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл, мах боловсруулах, консервлох, металл үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөллөө.




- Боловсруулсан малын мах 2025 оны эхний 11 сард 49.4 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буурлаа.
- Боловсруулсан махны биет хэмжээ буурсан ч үхэр, адууны махны боловсруулалт нэмэгдэж, боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэлчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар өслөө.



- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 153.8 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өссөн байна.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ нэмэгдсэн ч боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл бодит дүнгээр (2024 оны суурьтай үйлдвэрлэлчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар буурлаа.




- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 503.1 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ буурсан ч боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэлчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар буурлаа.




- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2025 оны эхний 11 сард 2.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 361.8 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх бодит үйлдвэрлэл* (2024 оны суурьтай үйлдвэрлэлчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар буурсан байна.




Барилгын салбарын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, вакум цонх болон хаалганы үйлдвэрлэл нэмэгдэж, металл бэлдэц болон цувимлын үйлдвэрлэл бууралттай хэвээр байна.




■ Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 2,091 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өссөн байна.



■ Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 5.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өслөө.



■ Металл бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 62.9 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар доогуур байна.



■ Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 38.3 мянган м.кв болж, өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар өслөө.



Нүүрсний тээвэр сэргэснээр төмөр замын ачаа тээвэр эхний 11 сард өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өслөө. Инфляцын нөлөөгөөр худалдаа, нийтийн хоолны салбарын бодит орлого буурсан үзүүлэлттэй байна.



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 10 сард нэрлэсэн дүнгээр 56.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар өссөн бол үнийн нөлөөг засварласан бодит дүнгээр 5.6 хувиар буурсан байна.



- 2025 оны эхний 10 сард нэрлэсэн дүнгээр зочид буудлын салбарын борлуулалтын орлого 19.5 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 11.8 хувиар өссөн байна.
- Инфляц эрчимжсэнээр үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлого 3.0 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 3.8 хувиар буурсан байна.



- Төмөр замаар 2025 оны эхний 11 сард 44.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8 хувийн өсөлттэй байна.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 20.1 хувийн өсөлттэй байна.
- Экспортын нүүрс тээврийн зай буурснаас үүдэн авто замаар 2025 оны эхний 3 улиралд 67.1 сая тонн ачаа тээвэрлэв.



- 2025 оны эхний 11 сарын байдлаар Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 804.2 мянгад хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.3 хувиар өссөн байна. Аравдугаар сард хүлээн авсан жуулчдын тоо нь мөн үед хүлээн авсан жуулчдын түүхэн дээд хэмжээ юм.

1.7 ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)2025 оны 3 дугаар улирал



Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлдэг худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны 3 дугаар улиралд 45.4 хувь болж, бизнесүүд эдийн засаг агшина гэсэн хүлээлттэй байна.

PMI
(50=өөрчлөлтгүй)

Year	Q1	Q2	Q3	Q4
2021	42.5	43.2	44.1	45.0
2022	41.8	42.5	43.2	44.0
2023	42.1	42.8	43.5	44.2
2024	42.4	43.1	43.8	44.5
2025	42.7	43.4	45.4	46.1

Эх сурвалж: Монголбанк

PMI, гол салбараар
(50=өөрчлөлтгүй)

Салбар	PMI
Аж үйлдвэр	46.8
Барилга	46.6
Дотоод худалдаа	41.3
Үйлчилгээ	37.6

Эх сурвалж: Монголбанк

PMI, аж ахуйн нэгжийн төрлөөр
(50=өөрчлөлтгүй)

Төрөл	PMI
Том	46.4
Дунд	36.7
Жижиг	36.0

Эх сурвалж: Монголбанк

PMI, үзүүлэлтүүдээр
(50=өөрчлөлтгүй)

Үзүүлэлт	PMI
Шинэ захиалга	46.8
Үйлдвэрлэл	46.6
Ажил эрхлэлт	41.3
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	37.6
Түүхий эд материалын нөөц	37.6

Эх сурвалж: Монголбанк

- Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг хэмждэг Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны 3 дугаар улиралд 45.4 хувь болж, өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар сайжирсан бол өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар доогуур гарлаа.

- Барилгын салбарын PMI өмнөх улирлаас 3.1 хувиар буурч, 37.6 хувь болж, сөрөг хүлээлттэй хэвээр байна.
- Аж үйлдвэрийн салбарын PMI өмнөх улирлаас 3.1 нэгж хувиар саарч, тус салбарын бизнес эрхлэгчид 3 улирал дараалан сөрөг хүлээлттэй байна.
- Харин үйлчилгээний салбарын PMI өмнөх улирлаас 6.5 нэгж хувиар сайжирсан ч 3 улирал дараалан, худалдааны салбар 4 улирал дараалан сөрөг хүлээлттэй байна.


- 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалттай том аж ахуйн нэгжүүдийн PMI өмнөх улирлаас 1.2 нэгж хувиар сайжирсан ч 3 улирал дараалан агшилтын мужид байна.
- Харин 1-2.5 тэрбум төгрөгийн борлуулалттай дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийн PMI өмнөх улирлаас 9.2 нэгжээр огцом буурч, 4 улирал дараалан сөрөг төлөвт байна.
- 1 тэрбум төгрөгөөс бага борлуулалттай жижиг бизнесүүдийн PMI 36.7 хувь болж, тогтмол сөрөг хүлээлттэй байна.

- Бизнесийн гол үзүүлэлтүүд 2025 оны 3 дугаар улиралд бүгд буурах хүлээлттэй гарлаа.



2025 оны эхний 11 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 24.0 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 3.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

ЭКСПОРТ
(сая ам.доллар)




- Экспорт 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 13,742 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар буурлаа.
- Нийт экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлээ.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ЭКСПОРТ (сая ам.доллар)



- Нүүрсний экспортын орлого 5,069 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 38 хувиар буурлаа.
- Зэсийн баямжалын экспортын орлого 5,067 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 73 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 981 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 583 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өслөө.

ИМПОРТ
(сая ам.доллар)



- 2025 оны оны 11 дүгээр сарын байдлаар импорт 10,211 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар буурсан байна.
- Нийт импортын 20.3 хувийг тоног төхөөрөмж, 16.4 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 13.2 хувийг барилгын материал, 10.7 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 9.4 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Ачааны тээврийн хэрэгслийн импорт 29.0 хувиар, авто бензиний импорт 7.4 хувиар, дизель түлшний импорт 1.0 хувиар, суудлын автомашины импорт 3.1 хувиар буурсан нь нийт импорт буурахад нөлөөллөө.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ИМПОРТ (сая ам.доллар)




- Нефтийн бүтээгдэхүүний импорт 1,683 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буурлаа.
- Тоног төхөөрөмжийн импорт 2,082 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 962 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар буурлаа.
- Барилгын материалын импорт 1,352 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар өслөө.
- Хүнсний импорт 1,095 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өслөө.




2025 оны 11 дүгээр сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 93 хувийг бүрдүүллээ.




- Нүүрсний экспортын биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 79.1 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар өслөө.



- Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 2,041 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 34.8 хувиар өслөө.



- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 8,068 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өслөө.




- Газрын тосны экспортын биет хэмжээ 2025 оны эхний 11 сард 3,233 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар буурлаа.




2025 оны эхний 11 сард хөдөө аж ахуйн экспорт өмнөх оны мөн үеийн түвшинд байна.


ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ
ЭКСПОРТ
(сая ам.доллар)




ХОНЬ ЯМААНЫ МАХ
(сая ам.доллар)




САМНАСАН НООЛУУР
(сая ам.доллар)



АРЬС ШИР
(сая ам.доллар)




БОЛОВСРУУЛСАН МАХ
(сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

АДУУ, ҮХРИЙН МАХ
(сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

УГААСАН НООЛУУР
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС
(сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ
ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС
(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн
сайн чанарын коксжих нүүрс)



- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2025 оны 11 дүгээр сарын дундаж үнэ 207 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар буурсан байна.

ЗЭС
(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)




- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2025 оны 11 дүгээр сарын дунджаар 11,687 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 31 хувиар өссөн байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ
(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн
агууламжтай төмрийн баяжмал)



- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2025 оны 11 дугаар дундаж үнэ 107 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн байна.

ГАЗРЫН ТОС
(\$/баррель, Brent)




- Бrent газрын тосны 2025 оны 11 дүгээр сарын дундаж үнэ 61 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 10 хувиар буурсан байна.



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 11 сард 19.2 сая тонн нүүрс, 4.4 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 51.5 мянган тонн жоншны баяжмал, 40.8 мянган тонн зэсийн баяжмал арилжаалаад байна.



- 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 2023 оноос хойш нийт 56.5 сая тонн нүүрс арилжиж, 5.9 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 11 сард 19.2 сая тонн нүүрс борлууллаа.



- 2025 оны 11 дүгээр сард нүүрсний дуудах дундаж үнэ 88 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 80 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 11 дүгээр сард хэлцлийн доод үнэ 40 ам.доллар, дээд үнэ 146 ам.долларт хүрэв.



- 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 7.5 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 500 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 11 сард 4.4 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.



- Төмрийн хүдэр болон баяжмалын 11 дүгээр сарын дуудах дундаж үнэ 67 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 76 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 11 дүгээр сард хэлцлийн доод үнэ 71 ам.доллар, дээд үнэ 85 ам.долларт хүрэв.



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ
(сая ам.доллар)

Сар	2023	2024	2025
1	-500	-1000	-1500
2	-600	-1200	-1800
3	-700	-1400	-2000
4	-800	-1600	-2200
5	-900	-1800	-2400
6	-1000	-2000	-2600
7	-1100	-2200	-2800
8	-1200	-2400	-3000
9	-1300	-2600	-3200
10	-1400	-2800	-3400
11	-1500	-3000	-3600
12	-1600	-3200	-3800
1	-1700	-3400	-4000
2	-1800	-3600	-4200
3	-1900	-3800	-4400
4	-2000	-4000	-4600
5	-2100	-4200	-4800
6	-2200	-4400	-5000
7	-2300	-4600	-5200
8	-2400	-4800	-5400
9	-2500	-5000	-5600
10	-2600	-5200	-5800
11	-2700	-5400	-6000
12	-2800	-5600	-6200
1	-2900	-5800	-6400
2	-3000	-6000	-6600
3	-3100	-6200	-6800
4	-3200	-6400	-7000
5	-3300	-6600	-7200
6	-3400	-6800	-7400
7	-3500	-7000	-7600
8	-3600	-7200	-7800
9	-3700	-7400	-8000
10	-3800	-7600	-8200
11	-3900	-7800	-8400
12	-4000	-8000	-8600
1	-4100	-8200	-8800
2	-4200	-8400	-9000
3	-4300	-8600	-9200
4	-4400	-8800	-9400
5	-4500	-9000	-9600
6	-4600	-9200	-9800
7	-4700	-9400	-10000
8	-4800	-9600	-10200
9	-4900	-9800	-10400
10	-5000	-10000	-10600
11	-5100	-10200	-10800
12	-5200	-10400	-11000
1	-5300	-10600	-11200
2	-5400	-10800	-11400
3	-5500	-11000	-11600
4	-5600	-11200	-11800
5	-5700	-11400	-12000
6	-5800	-11600	-12200
7	-5900	-11800	-12400
8	-6000	-12000	-12600
9	-6100	-12200	-12800
10	-6200	-12400	-13000
11	-6300	-12600	-13200
12	-6400	-12800	-13400
1	-6500	-13000	-13600
2	-6600	-13200	-13800
3	-6700	-13400	-14000
4	-6800	-13600	-14200
5	-6900	-13800	-14400
6	-7000	-14000	-14600
7	-7100	-14200	-14800
8	-7200	-14400	-15000
9	-7300	-14600	-15200
10	-7400	-14800	-15400
11	-7500	-15000	-15600
12	-7600	-15200	-15800
1	-7700	-15400	-16000
2	-7800	-15600	-16200
3	-7900	-15800	-16400
4	-8000	-16000	-16600
5	-8100	-16200	-16800
6	-8200	-16400	-17000
7	-8300	-16600	-17200
8	-8400	-16800	-17400
9	-8500	-17000	-17600
10	-8600	-17200	-17800
11	-8700	-17400	-18000
12	-8800	-17600	-18200
1	-8900	-17800	-18400
2	-9000	-18000	-18600
3	-9100	-18200	-18800


Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн




Инфляц 2025 оны 11 дүгээр сард 8.2 хувьд хүрч, өмнөх сараас 1.0 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх сараас 1.0 нэгж хувиар буурахад өрхийн цахилгааны төлбөрийн суурь үеийн нөлөө арилсан нь нөлөөлсөн байна. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.6 хувиар өслөө.




- Инфляц 2025 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд 8.2 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.4 нэгж хувь (30 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 5.8 нэгж хувь буюу 70 хувийг эзэлж байна.



- 2025 оны 11 дүгээр сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.6 хувиар өслөө.
- Сарын инфляц 0.6 хувь гарахад хувцас, бөс бараа, гутлын үнэ 1.9 хувиар, хүнсний ногооны үнэ 2.5 хувиар, дизель түлш 6.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2025 оны 11 дүгээр сард суурь инфляц 7.5 хувь гарч, нийт инфляцын 4.6 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн сар өөрчлөгдөөгүй байна.



- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт эрчимжсэнээр жилийн инфляцын 11.8 хувийг бүрдүүллээ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өслөө.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 18.8 хувиар өслөө.




Олон улсад чингэлэг тээврийн үнэ 1,957 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 45 хувиар буурлаа. Хүнсний үнийн индекс 2025 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Хүнсний инфляц 2025 оны 11 дүгээр сард 12.0 хувь болж, нийт инфляцын 3.1 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц өмнөх сараас эрчимжихэд мах, гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлт нөлөөллөө.
- Хүнсний бус инфляц 6.8 хувь болж, нийт инфляцын 5.1 нэгж хувийг бүрдүүллээ.




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 11 дүгээр сард дунджаар 3,571 төгрөг болж, өмнөх сараас 0.6 хувиар чангарлаа.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2025 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1.0 хувиар өслөө.



Эх сурвалж: Drewry World Container Index

- АНУ-ын тарифын бодлогоос үүдэлтэйгээр дэлхийн чингэлэг тээврийн үнэ өсөөд байсан бол 6 дугаар сараас эхлэн аажмаар буурч эхэллээ.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 1,957 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 45 хувиар буурсан байна.
- Чингэлэг тээврийн үнэ буурч байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг бууруулж байна.




Эх сурвалж: FAO

- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2025 оны 11 дүгээр сард 125.1 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар, өмнөх сараас 1.2 хувиар тус тус буурсан байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр үр тарианы үнэ өссөн бол сүүн бүтээгдэхүүн, мах, элсэн чихэр болон ургамлын тосны үнэ буурсан байна.




Төсвийн нийт орлого нүүрсний үнэ болон экспортын орлогын бууралтаас шалтгаалан 2025 оны эхний 11 дүгээр сард 27.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 171.5 тэрбум төгрөг буюу 0.6 хувиар буураад байна.

ТӨСВИЙН ОРЛОГО
(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)




- Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 25.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 471.9 тэрбум төгрөг буюу 1.8 хувиар буурсан байна.
- Төсвийн орлогын бууралтад нийт АМНАТ-ийн орлого 903.2 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оноос 20.4 хувиар, ААНОАТ 755.7 тэрбум төгрөг буюу 13.3 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ТӨСВИЙН ЗАРЛАГА
(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



- Төсвийн зарлага 2025 оны 11 дүгээр сард 27.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 их наяд төгрөг буюу 10.8 хувиар нэмэгдсэн байна.
- Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2025.01.01-ний өдрөөс өмнөх оны инфляцын түвшинд уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлсэн.
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 5.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 20.2 хувиар, тэтгэвэр, тэтгэмж 7.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар тус тус өссөн байна.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ
(их наяд төгрөг)



- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 1.8 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад нүүрсний үнийн бууралттай холбоотойгоор АМНАТ болон ААНОАТ-ын орлого буурснаар төсвийн орлого төвлөрүүлэлт саарсан нь голлох нөлөө үзүүлээ.


ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)
(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг
Баруун тэнхлэг: ДНБ-д эзлэх хувь)



- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны гуравдугаар улиралд 35.7 их наяд төгрөг буюу ДНБ-д эзлэх хувь 39.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар өссөн байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 11 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өсөж, 45.8 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 11 дүгээр сард 43.1 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 21.0 хувьд хүрлээ.




- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 11 дүгээр сарын эцэст 45.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 8.8 нэгж хувь, гадаад валютын хадгаламж 2.1 нэгж хувь, гадаад валютын харилцах -1.3 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 30.1 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 24.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар, өмнөх сараас 3.1 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар өслөө.





- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2025 оны 11 дүгээр сарын эцэст 43.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 21.0 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурсан байна.



- Банкнуудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 11 дүгээр сард 17.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өссөн байна.
- Банкнуудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 11 дүгээр сард 11.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар, өмнөх сараас 0.5 нэгж хувиар тус тус буурчээ.



Ажиллагчдын тоо 1 сая 394 мянгад хүрсэн ч өсөлтийн хурд саарч, ажилгүй иргэдийн бууралтын нөлөөгөөр ажиллах хүчний өсөлт удааширч, ажиллах хүчний оролцооны түвшин 62.7 хувь болж буурлаа.



- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 33 мянга буюу 2.5 хувиар нэмэгдэж 1 сая 394 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 238 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2025 оны 3 дугаар улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 25 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 8 мянгаар тус тус өссөн байна.
- Ажиллагчдын тооны өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлтийн нөлөөгөөр ажиллагчдын тоо 21 мянгаар нэмэгдсэн мөн уул уурхай салбарын ажиллагчид 20 мянгаар нэмэгдэж түүхэн дээд түвшиндээ хүрч өссөн нь голчлон нөлөөлжээ. Түүнчлэн барилга, боловсруулах салбарын ажиллагчид нэмэгдсэн нь нийт ажиллагчдын өсөлтийг дэмжсэн байна.
- Харин тээвэр, цахилгаан ус, худалдаа, үйлчилгээний салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.
- Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 7.5 мянгаар буурснаар ажилгүйдлийн түвшин 5.5 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурсан байна.
- Харин ажиллах хүчний оролцооны түвшин ажилгүй иргэдийн буурсан нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурч 62.7 хувьд хүрээд байна.
- Дундаж цалингийн хэмжээ 2025 оны III улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 10 хувиар өсөж, 2 сая 714 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын голч цалин 288 мянган төгрөгөөр буюу 14 хувиар өсөж, 2 сая 312 мянган төгрөг (дундаж цалингаас 402 мянган төгрөгөөр бага) болов. Энэ нь ажилчдын талаас илүү нь 2.3 сая төгрөгөөс бага цалин авч байгааг илэрхийлж байна.
- Хэрэглээний үнийн индексээр засварлагдсан бодит цалин өмнөх оны мөн үеэс 1 хувиар өсөж 1 сая 706 мянган төгрөгт хүрлээ.

Өрхийн бодит орлогын өсөлт саарч, 4.0 хувь боллоо.

ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ
(хувь)

■ Бусад орлого
■ ХАА-н орлого
■ Тэтгэвэр, тэтгэмж
■ Цалин хөлс
■ Өрхийн бодит орлого

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН НЭРЛЭСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА
БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ
(хувь)

Орлого
Зарлага
Хадгаламж

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО
(сая төгрөг)

— 1.6 саяас бага — 1.6 саяас их

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ
(хувь)

■ Улаанбаатар
■ Сумын төв
■ Хөдөө

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн бодит орлого 4.0 хувь болж, саарлаа.
- Бодит орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс нэрлэсэн дүнгээр 251.8 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 30.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.


- Өрхийн зарлагын өсөлт орлогын өсөлтийг давж, иргэдийн хадгаламжийн өсөлт үргэлжлэн удааширсаар байна.

- Бага орлоготой өрхийн орлого төдийлөн өсөлтгүй хэвээр байна.
- Нийт өрхийн 28.8 хувийг бүрдүүлж буй 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүдийн сарын дундаж нэрлэсэн орлого 949 мянган төгрөг буюу өмнөх улирлаас 45 мянган төгрөгөөр буурсан бол 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3.4 сая төгрөг болж, өмнөх улирлынхаас 164 мянган төгрөгөөр өссөн байна.

- Хөдөөгийн өрхийн бодит орлого Улаанбаатар болон улсын дунджаас өндөр байгаа ч өмнөх улирлынхаасаа 4 нэгж хувиар буурсан байна.
- Үүнд 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөдөө суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ.



Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 3 дугаар улиралд 279.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 29.0 мянгаар буюу 11.6 хувиар нэмэгдлээ.




- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 3 дугаар улиралд 279.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 29.0 мянгаар буюу 11.6 хувиар нэмэгдлээ.
- Уг өсөлтийн 17.7 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 8.9 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүллээ.
- Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдэж байгаа нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна.
- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо худалдааны салбарт 3.0 мянга, үйлчилгээний салбарт 3.1 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 24 хувиар өссөн байна.
- Үйл ажиллагаа явуулж буй 115.0 мянган ААН-ийн 99.7 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 96.7 хувийг бүрдүүлж байна.
- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2025 оны 3 дугаар улиралд 98.4 болж өмнөх оны мөн үеэс 14.3 нэгжээр муудлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 2.0 нэгжээр буурсан.
- Мөн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 19.1 нэгжээр буурсан бөгөөд үүнд бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлт муудсан нь нөлөөллөө.




ОХУ-ын эдийн засаг 2025 оны 3 дугаар улиралд 0.6 хувиар өслөө. Инфляцын түвшин 2025 оны 11 дүгээр сард 6.6 хувьд хүрч, өмнөх сараас 1.1 нэгж хувиар буурлаа.




- ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 0.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурлаа.



- 2025 оны 10 дугаар сарын байдлаар экспорт 36.1 тэрбум ам.доллар, импорт 25.0 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 11.1 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2025 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар буурлаа.
- Импорт 2025 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар буурлаа.




- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- Инфляцын түвшин 2025 оны 11 дүгээр сард 6.6 хувь болж, өмнөх сараас 1.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар буурсан байна.
- ОХУ-ын төв банкаас 10 дугаар сарын 24-ний өдөр бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, 16.5 хувьд хүргэх шийдвэр гаргасан.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2025 оны 11 дүгээр сард 48.3 болж, өмнөх сараас 0.3 нэгжээр өслөө.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 4.1 хувь болж, өмнөх сараас 1.0 нэгж хувиар өслөө.



Хэдийгээр дотоод эрэлт сул хэвээр байгаа ч экспорт, дотоодын эрэлт нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засаг 2025 оны 3 дугаар улиралд 4.8 хувиар өслөө.



- БНХАУ-ын эдийн засаг 2025 оны 3 дугаар улиралд 4.8 хувиар өслөө.
- Экспорт 2025 оны ссард 1.1 хувиар буурч, импорт 2025 оны 10 дугаар сард 1.0 хувиар өсөж өмнөх сараас суларсан үзүүлэлттэй байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.




- Аж үйлдвэрийн гарц 2025 оны 10 дугаар сард 4.9 хувиар өсөж, өмнөх сараас өсөлт саарлаа.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны борлуулалт 2025 оны 10 дугаар сард 2.9 хувь болж саарсан байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.



- Хэрэглээний үнийн индекс 2025 оны 10 дугаар сард 0.2 хувь гарч дефляцийн бүсээс гарлаа.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2025 10 дугаар сард -2.1 хувь гарч, үнийн уналт өмнөх сараас саарлаа.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 10 дугаар сард 49.0 болж, агшилтыг илэрхийлсэн хэвээр байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас буурсан боловч тэлэлтийг илэрхийлэх 50-аас дээш түвшинд хадгалагдаж байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжилтийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажиг эрлэлт, түүний эдийн нөөц зэвэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ